



ОЛОН УЛСЫН ТӨВД СУДЛАЛЫН НИЙГЭМЛЭГИЙН XIII ХУРЛЫН ЗАР

Улаанбаатар, Монгол

2013 оны 7 сарын 21-27

Монголын Шинжлэх Ухааны Академи, Монгол Улсын Их Сургууль, Олон Улсын Төвд Судлалын Нийгэмлэг (OUCTH) хамтран Олон улсын Төвд Судлалын Нийгэмлэгийн XIII хурлыг Улаанбаатар хотноо 2013 оны 7 сарын 21-27 ны өдрүүдэд зохион байгуулах гэж байна. Др. С.Чулуун (Монголын Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэн), Др. У.Булаг (Кэмбриджийн Их сургууль), Др. Улрика Роеслер (Оксфордын Их Сургууль) нар хамтран зохион байгуулагчаар оролцож байна. Хурал зохион байгуулагчид энэхүү урилгын хамт та бүхний хуралд оролцох илтгэл болон хэлэлцүүлгийн саналыг авч буйдаа тааламжтай байна.

Хурал зохион байгуулагчид нь Монголын Бурханы шашинтны төв, Үндэсний төв номын сан, Монголын Түүхийн үндэсний музей, Үндэсний Архив зэрэг Монгол дахь ивээн тэтгэгч байгууллагуудтай хамтран ажиллах болно. Хурлын үйл ажиллагаа Монгол Улсын Их Сургуулийн хичээлийн байрнуудад явагдана.

Бид олон улсын төлөөлөгчдийн Монголд байх хугацааны тээврийн зардал, хоёр оройны хоол, хүлээн авалтын үйл ажиллагаа, өдрийн хоол, хурлын зардлыг дааж байгаа бөгөөд өнөөгийн эдийн засгийн байдлын улмаас улс хоорондын аялалын билет болон зочид буудлын зардлыг даах боломжгүйдээ харамсаж байна. Бид хэдийгээр бусад байгууллагатай холбоо тогтоож санхүүгийн эх үүсвэр олохоор оролдож байгаа боловч, та бүхнийг аль болохоор өөрсдийгөө санхүүжүүлэхийг хүсэж байна.

Зочид буудал: Улаанбаатарт оюутны байрнаас эхлээд янз бүрийн зэрэглэлийн зочид буудалд буух боломжтой. Бид Олон Улсын Төвд Судлалын Нийгэмлэгийн гишүүдийн буух зочид буудлын үнийг боломжийн үнээр ярьж тохирох болно. Онлайн бүртгэлийн үйлчилгээ 2012 оны 6 сараас эхлэх болно.

Бүртгэлийн хураамж: USD \$250

Хуралд оролцох төлөөлөгчдийн талаар дараахь зүйлийг анхааралдаа авахыг Олон Улсын Төвд Судлалын Нийгэмлэгийн хурал зохион байгуулагчид, ерөнхийлөгч, нарийн бичгийн дарга нараас хүсье.

1. Хуралд оролцогчид 20 минутын хугацаанд илтгэлээ тавих бөгөөд илтгэл нь Олон Улсын Төвд Судлалын хүлээн зөвшөөрөгдсөн Англи, Төвд, Франц болон Герман хэлээр тавигдана. Тодорхой тооны илтгэлүүд хуралдааны явцад Монгол хэлээр тавигдахыг зөвшөөрнө.
2. Хэрэв та хурлын явцад тодорхой сэдвийг хэлэлцүүлэх саналтай, дугуй ширээний ярилцлага хэлэлцүүлэг хийх буюу семинар хийх хүсэлтэй байгаа бол тухайн хэлэлцүүлэх сэдвээ (1 хуудаснаас багагүй) тодорхойлж саналаа 2012 оны 10 сарын 1-нээс өмнө ирүүлнэ үү.
3. Хуралд оролцогчид нь бусад хуралд уншигдсан буюу сэтгүүлд хэвлэгдсэн материалаар оролцож болохгүй. Бүх материал нь суурь судалгааны үр дүнг харуулсан байх ёстой ба аливаа материалаас дахин иш татсан эсвэл хоёрдогч эх сурвалжид аль хэдийн тавигдсан дата|мэдээлэл ашиглаж болохгүй. Илтгэл нь тулгуур эх хэлээр бичигдсэн |бичгийн болон аман| эх сурвалжид тулгуурлах буюу Төвд судлалын салбарт дэвшил болохуйц санааг дэвшүүлэх ёстой.
4. Бүх хуралд оролцогч нь өөрсдийн итгэлийн абстрактыг |хураангуйг| явуулах шаардлагатай.
 - a) Олон Улсын Төвд Судлалын Нийгэмлэгийн хуралд анх удаа оролцож буй оюутнууд нь өөрсдийн сургуулийн аль нэгэн эрдэмтэн багшаас тодорхойлолт захиа болон богино CV, хэвлүүлсэн бүтээлийн жагсаалтыг ирүүлнэ үү.
 - b) Хуралд анх удаа оролцож байгаа бүх төлөөлөгчид буюу Бритиш Колумбия их сургуульд болсон Олон Улсын Төвд Судлалын Нийгэмлэгийн XII хуралд оролцогчид, оюутнууд нь 2013 оны 1 сарын 1 нээс өмнө өөрсдийн илтгэлийн 1 бүтэн ба тал хуудас хураангуйг явуулна уу. Мөн дугуй ширээний ярилцлага буюу хэлэлцүүлэгт оролцогчид хураангуйгаа явуулна уу.
 - c) Бусад бүх оролцогчид илтгэлийн хураангуйгаа (1 хуудаснаас багагүй) дээрхи дурдсан хугацаанд явуулна уу.
 - d) Бүх хураангуйг хянаж үзээд хэрэв олон улсын эрдэм шинжилгээний ажлын стандарт шаардлагыг хангаагүй илтгэл байвал хуралд тавихыг хүлээн зөвшөөрөхгүй болно.
 - e) Аливаа институтэд харъяалалгүй судлаач эрдэмтдийг илтгэлээ өгөхийг дэмжинэ.

5. Хуралд ажиглагчаар оролцогчид, оюутнууд өөрсдийн харъяа их дээд сургуулийн тодорхойлолт, өөрсдийн ажил байдал болон судалгааны чиглэлийг тодорхойлсон захиаг 2013 оны 1 сарын 1-нээс өмнө илгээнэ үү Энэ нь мөн чөлөөт судлаач эрдэмтдэд хамаарах бөгөөд тэд нэр хүнд бүхий Төвд судлаачаас тодорхойлолт захиаг авч бидэнд илгээх хэрэгтэй.
6. Хуралд оролцогчид нь тодорхой сэдвээр ярилцлага буюу хэлэлцүүлэг зохион байгуулж болох боловч, тухайн хэлэлцүүлэгт урьж оролцуулах бусадтайгаа холбоо барих үүргээ өөрөө хүлээх ба тэр тухай төлөвлөгөөгөө зохион байгуулагчдад мэдээлж байх хэрэгтэй. Дугуй ширээний хэлэлцүүлэгт оролцогчид нь хурлын үед бусад салбар хуралдаанд оролцох боломжгүй.
7. Хэрэв та ОУТСН-ын XIII хуралд оролцох сонирхолтой бол өөрийн өргөдөлийн маягтыг бөглөж, илтгэлийн хураангуйн хамт 2013 оны 1 сарын 1-ний дотор илгээнэ үү. Таны өргөдлийг хүлээж аваад тус хуралд оролцох боломжтой эсэхийг 2013 оны 2 сарын сүүлээр мэдэгдэнэ.
8. Хэрэв таныг ОУТСН-ын XIII хуралд оролцохыг хүлээн зөвшөөрсөн бол та өөрийн бүртгэлийн хураамжаа 2013 оны 3 сарын 31-ний дотор тушаасан байх шаардлагатай. Бид семинарын зардлыг урьдчилан төлсөн байх хэрэгтэй бөгөөд тухайн үйл ажиллагааны цаашдын санхүүжилтэд чухал хэрэгтэй.
9. Бүх хуралд оролцогчид нь өөрсдийн виз болон аялалын даатгалыг өөрсдөө хариуцан зохион байгуулна уу. Монголын Шинжлэх Ухааны Академи нь дээрхи асуудалтай холбоотой ямар нэгэн зүйлд хариуцлага хүлээхгүй. Хэрэв та хүсэлт гаргавал виз авахад хэрэгтэй урилга захиаг олгох болно.
Илтгэлийн хураангуйг хүлээн авах сүүлчийн хугацаа нь 2013 оны 1 сарын 1 болно. Хуралд оролцох өргөдлийн хариу нь хурлын урилга хэлбэрээр танд хүрэх бөгөөд түүгээр та Монголд нэвтрэн орох визээ мэдүүлэх боломжтой.

Зарим нэг улсаас хуралд оролцогчдын хувьд 2013 оны 1 сарын 1-нд таны өргөдөл, илтгэлийн хураангуйг хүлээн авч ОУТСН-ын XIII хуралд оролцох урилга явуулах нь таныг паспорт авахад хангалттай хугацаа олгохгүй бид ойлгож байна.

Тиймээс дээрхи тохиолдолд хуралд оролцох хүсэлтэй хүмүүс өөрсдийн өргөдөл болон илтгэлийн хураангуйг 2012 оны 10 сарын 1-ний дотор илгээж, бид таны материалыг хянаж үзээд оролцох боломжтой бол 2012 оны 11 сард танд хуралд оролцох урилгыг илгээх болно.

ОУТСН-ын XIII хуралын тухай веб сайт: <http://www.iats.info/the-thirteenth-seminar-of-the-iats-%E2%80%93-ulaanbaatar-2013/>. ОУТСН-ын талаархи ерөнхий мэдээллийг авахыг хүсвэл: <http://www.iats.info/>

ОУТСН-ын XIII хуралын талаар харилцахыг хүсвэл: iats2013@innerasiaresearch.org

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл:

<http://www.thlib.org/collections/texts/jiats/#wiki=https://collab.itc.virginia.edu/access/wiki/site/0b308aa3-d044-469b-009a-d34c7841413d/jiats%20home%3A%20right1.html#ixzz1xG8bmEw6>